



# **“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН-2024**

**УЛААНБААТАР**

## 1. Үнэлгээний зорилго

- 1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.
- 1.3. Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилд 2-оос доошгүй удаа тооцно.
- 1.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.5. Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээллэнэ.

## 2. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11		92%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, гэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	5		83%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5		83%
5	Эрсдэлийн удирдлага	8	8		100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	5		83%
7	Ороцогч талуудын эрх ашиг	8	7		88%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчийн эрх	10	9		90%
	<b>НЭГДСЭН ДҮН</b>	<b>72</b>	<b>66</b>		<b>91%</b>

## 3. Үнэлгээний аргачлал

- 3.1 Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо

тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулав.

3.2 Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

3.2.1 авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй

3.2.2 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх

3.2.3 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн

3.2.4 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай

“Багануур” ХК нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-уудад зориулсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний асуулга”-ыг ашиглан үнэлгээ хийсэн. Багануур ХК-ийн засаглалын нэгдсэн үнэлгээ нь 91 хувьтай байгаа нь засаглал хэвийн буюу эрсдэлгүй байна.

## Компанийн засаглалын үнэлгээний асуулга

*Кодексийн хэрэгжилтийг "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнахдаа кодекс дурдсан зарчмын зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг тайлбар хэсэгт нарийвчлан тайлбарлана.*

### НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

**ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна**

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	1. "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 05-р сарын 07-ны өдрийн 14 тоот тогтоолоор "ТУЗ-ийн үйл ажиллагааны болон хороодын журам"-ыг баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Энэхүү журмаар ТУЗ-ын дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг зохицуулж өгсөн. /Журмыг хавсаргав/ 2. Мөн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулах журмын төслийг боловсруулан ТУЗ-өөр хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. /Журмын төслийг хавсаргав/	2	100%
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	"Багануур" ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 05-р сарын 07-ны өдрийн 14 тоот тогтоолоор баталсан "ТУЗ-ийн үйл ажиллагааны болон хороодын журам", ТУЗ-ын 2024 оны 10-р сарын 28-ны өдрийн 30 тоот тогтоолоор баталсан "Багануур" ХК-ийн Залгамж халааны бодлого"-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. /Журмыг хавсаргав/ Багануур ХК нь төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани тул Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулах нийтлэг журмыг Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 85 дугаар тогтоолоор нарийвчлан зохицуулдаг. Мөн Төрийн төлөөллийн хувьцаа эзэмшигчийн төлөөлөл хэрэгжүүлэгч ТУЗ-ын гишүүний үйл ажиллагааны журам болон хэрхэн томилох асуудлыг Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор нарийвчлан зохицуулсан байдаг.	2	100%
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн жилийн эцсийн тайлан, хөрөнгийн биржийн цахим хуудас болон компанийн цахим хуудсанд ТУЗ-ийн гишүүдийн мэдээллийг байршуулдаг. Цахим холбоос: <a href="https://shorturl.at/bPDfX">https://shorturl.at/bPDfX</a> Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2022 он, 2023 он, 2024 оны цалин урамшууллын мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод болгосон. Цахим холбоос: <a href="https://shorturl.at/IAOVW">https://shorturl.at/IAOVW</a> ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын жилийн ажлын гүйцэтгэлийг ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд тусгадаг.	2	100%

4	<i>1.4. Компани нь ТУЗ-ийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, "ТУЗ-ийн үйл ажиллагааны болон хороодын журам"-д ТУЗ болон хороодын бүтэц, бүрэлдэхүүн, гишүүдэд тавигдах шаардлагыг тусгасан байдаг. ТУЗ-ийн бүрэлдэхүүний аль нэг хүйсийн эзлэх хувийг гучаас доошгүй байх зохицуулалтыг ТУЗ-ийн "Нэр дэвшүүлэх хорооны ажиллах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулахаар тусган ТУЗ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн бөгөөд 2025 оны 1-р улиралд багтаан батлан мөрдөж эхэлнэ. /журмын төсөл болон хороодын журмыг хавсаргав/	2	100%
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүдийг компанийн үйл ажиллагаатай танилцуулах чиглүүлэх сургалт болон шаардлагатай тохиолдолд мэдлэг, ур чадвар, мэдээлэл олгох сургалтанд хамруулдаг. ТУЗ-ийн гишүүд нарийн бичгийн даргад зориулсан сургалтын бодлого батлах тухай бодлогын баримт бичгийг боловсруулж ТУЗ-өөр хэлэцүүлэхээр хүргүүлсэн бөгөөд 2025 оны 1-р улирал багтаан батлан мөрдөж ажиллана. /журмын төслийг хавсаргав/	2	100%
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохиистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагын талаар ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулах журмын төсөлд тусгасан. /Журмын төслийг хавсаргав/	1	50%
ДҮН				11	92%
<b>ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b> ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэмд зааснаар ТУЗ нь 12 гишүүнтэй байх бөгөөд үүний 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байна гэж заасан. Компанийн ТУЗ нь 4 хараат бус гишүүнтэй. ТУЗ-ийн дарга нь ердийн гишүүн байдаг. ТУЗ-ийн дэргэдэх хороо тус бүрийн 2024 оны ажлын тайланг ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд тусгасан. /Тайланг хавсаргав/	2	100%

8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь 2019 онд баталсан "ТУЗ-ийн үйл ажиллагааны болон хороодын журам"-ыг баримтлан ажилладаг. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга биш бөгөөд хараат бус гишүүн ажилладаг. /ТУЗ-ийн хороодын гишүүдийг томилсон тогтоол болон Хараат бус гишүүдийг томилсон ХЭХ-ийн тогтоолыг хавсаргав/ Компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд аудитын хорооны хуралд оролцох тохиолдолд зөвхөн хорооны хүсэлтээр оролцдог буюу Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 3.4 дэх хэсэгт заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн хурал болон хороодын хуралд компанийн төлөөллийг оруулах эсэхийг тухайн хурал даргалагч шийдвэрлэнэ.	2	100%
9	<i>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо нь 2019 онд баталсан "ТУЗ-ийн үйл ажиллагааны болон хороодын журам"-ыг баримтлан ажилладаг. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга биш бөгөөд хараат бус гишүүн ажилладаг. Компанийн гүйцэтгэх удирдлага цалин урамшууллын хорооны хуралд оролцох тохиолдолд зөвхөн хорооны хүсэлтээр оролцдог буюу Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 3.4 дэх хэсэгт заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн хурал болон хороодын хуралд компанийн төлөөллийг оруулах эсэхийг тухайн хурал даргалагч шийдвэрлэнэ. Цалин урамшууллын бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж ТУЗ-өөр хэлэцүүлэхээр хүргүүлсэн. /Журмын төсөл хавсаргав/	2	100%
10	<i>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн 2019 онд баталсан "ТУЗ-ийн үйл ажиллагааны болон хороодын журам"-ыг баримтлан ажилладаг. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга биш бөгөөд ердийн гишүүн ажилладаг. ТУЗ-ын 2024 оны 10-р сарын 28-ны өдрийн 30 тоот тогтоолоор баталсан "Багануур" ХК-ийн Залгамж халааны бодлого"-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. /Залгамж халааны бодлогыг хавсаргав/	2	100%
11	<i>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 8.4 дэх хэсэгт дурдсанаар холбогдох асуудлаар түр хороо байгуулах боломжтой. Өнөөдрийн байдлаар Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ "Аудитын хороо", "Цалин урамшууллын хороо", "Нэр дэвшүүлэх хороо"-той. Эдгээр хороод нь үйл ажиллагааны журамтай бөгөөд чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй.	2	100%

	<i>турилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i>		Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 84, 85 дугаар тогтоолын дагуу сонгон шалгаруулалтаар ажиллаж байгаа тул мэргэжил боловсрол, туршлагын хувьд шалгарсан хүмүүс байна.		
ДҮН				10	100%
<b>ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b>					
<b>ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана</b>					
12	<i>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн мэдээллийн үйл ажиллагааны журам, мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмын дагуу мэдээллүүдийг тодорхойлж нийтэд ил тод болгох мэдээллийг хууль журмын дагуу компанийн албан ёсны цахим хуудас /www.baganuurmine.mn / болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, олон нийтэд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг нээлттэй тайлагнадаг.	2	100%
13	<i>3.2. ТУЗ нь энэхүү кодексын заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны цахим хуудас /www.baganuurmine.mn /-аар компанийн үйл ажиллагааны тайланг жилээр, санхүүгийн тайланг улирал, жилээр нээлттэй тайлагнадаг. Мөн компанийн мэдээллийн үйл ажиллагааны журам, мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмын дагуу мэдээллүүдийг тодорхойлж нийтэд ил тод болгох мэдээллийг хууль журмын дагуу цахим хуудсаар дамжуулан мэдээлдэг.	1	50%
14	<i>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны тайланг жилээр, санхүүгийн тайланг улирал, жилээр олон нийтэд нээлттэй тайлагнадаг. Санхүүгийн бус тайлангийн хүрээнд жилийн үйл ажиллагааны тайланд эдийн засгийн орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, хүний нөөц, нийгмийн хариуцлага, байгаль орчны хяналт, нөхөн сэргээлт, хамтын ажиллагаа /гадаад харилцаа, орон нутаг/, хөндлөнгийн аудитын дүгнэлтийн талаарх мэдээ мэдээллийг оруулсан. Цахим холбоос <a href="https://shorturl.at/P2DKD">https://shorturl.at/P2DKD</a>	2	100%
ДҮН				5	83%
<b>ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>					
<b>ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана</b>					

15	<i>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Аудитын хорооны үйл ажиллагааны журмын 2.1.3-т Хөндлөнгийн аудитортой хамтран ажиллах тухай тусгасан бөгөөд журмын хэрэгжилтэнд ТУЗ хяналт тавьж ажилладаг.	2	100%
16	<i>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Хөндлөнгийн аудитораар төрийн аудит ордог бөгөөд аудитын тайланг жил бүр хувьцаа эзэмшигчдийн хуралд Компанийн ерөнхий нягтлан бодогч танилцуулдаг. Цаашид хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, мэдээлэл өгдөг байх чиг үүргийг зохицуулсан баримт бичигтэй болохыг зорьж ажиллана.	1	50%
17	<i>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн бүтцэд тусгасны дагуу Дотоод хяналт шалгалтын алба ажилладаг бөгөөд албаны бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг ТУЗ-аас баталсан Дотоод хяналт шалгалтын албаны ажиллах журмаар зохицуулдаг. Цаашид дотоод аудитын талаарх мэдээ, тайланг жилийн үйл ажиллааны тайланд тусгаж компанийн цахим хуудсанд байршуулж ажиллана.	2	100%
ДҮН				5	83%
<b>ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>					
<b>ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина</b>					
18	<i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Аудитын хорооны үйл ажиллагааны журмын 2.1.1-т Дотоод хяналт, эрсдлийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгасан бөгөөд журмын хэрэгжилтэнд ТУЗ хяналт тавьж ажилладаг. Эрдэнэс Монгол ХХК-ийн 2024 оны 03 сарын 27-ны өдрийг 24-р тогтоолоор батласан "Эрсдлийн удирдлагын бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж ажилладаг. Дээрх журамтай уялдуулж компанийн Эрсдэлийн удирдлагын журмын төслийг боловсруулан ТУЗ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. /Журмын төслийг хавсаргав/	2	100%



19	<p><b>5.2. Төлөвлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-ын дэргэдэх Аудитын хорооны хэрэгжүүлэх чиг үүрэгт эрсдлийн удирдлагын талаар хийж хэрэгжүүлэх ажлын талаар тусган ажилладаг. Мөн ТУЗ болон Удирдлагын багаас эрсдэлийг тухай бүр үнэлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Цаашид ТУЗ-ын дэргэд эрсдлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорьж ажиллана.</p>	2	100%
20	<p><b>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>* Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан "Компанийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа, түүнийг төлөвлөх, зохион байгуулах журам"-ыг мөрдөж ажилладаг. * 2021 онд Франц улсын олон улсын аудитын "Афнор" группээс Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO45001:2018 стандартыг хэрэгжүүлэгч байгууллагаар шалгарч баталгаажилтын гэрчилгээг авч, 2023 оны 08-р сар ISO45001:2018 стандартын 2 дахь удаагийн магадлан аудитыг "Мон Сертф" ХХК-ийн аудитын баг хийж гүйцэтгэсэн. * 2013 онд Төрийн өмчид компаниудын дотроос анх удаа Нийгмийн хариуцлагын стратегийг батлан хэрэгжүүлж ажиллаж байсан бөгөөд цаашид уг стратегийг сайжруулан үргэлжлүүлж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. * Мөн ТУЗ болон Удирдлагын багаас эрсдэлийг тухай бүр үнэлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Жилийн үйл ажиллагааны тайланд байгаль орчин, нийгмийн хариуцлагын талаар тусгаж компанийн цахим хуудсанд байршуулдаг.</p>	2	100%
21	<p><b>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-ын 2024 оны 10-р сарын 28-ны өдрийн 30 тоот тогтоолоор баталсан "Багануур" ХК-ийн Комплайнсын хяналтын заавар, бүтэц"-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. /Журмыг хавсаргав/</p>	2	100%

	<i>төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.</i>				
ДҮН				8	100%
<b>ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b> Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 4-р сарын 27-ны өдрийн 04-р тогтоолоор олгогдсон эрхийн хүрээнд ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамж, бусад зардлыг Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар баталдаг.	2	100%
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн ажилтнуудын цалин хөлс, цалингийн нэмэгдлийг бодож олгох журам, Ажилтнуудын сарын ажлын үр дүнгээр шагнал цалин олгох журам, Жилийн ажлын үр дүнгээр шагнал олгох журам, Ур чадварын нэмэгдэл олгох журмуудад ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг тусгасан.	2	100%
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	Цаашид хэрэгжүүлж ажиллана	ТУЗ-аас Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэлийг улирал бүр дүгнэн ажилладаг. Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 сарын 03-ны өдрийн 184-р тогтоолоор "Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам" мөрдөн ажиллаж байна. Цаашид жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж, цахим хуудсанд байршуулан ажиллана.	1	50%
ДҮН				5	83%
<b>ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</b> Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	<i>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллахад байнга анхаардаг. Бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан ТУЗ-аар хэлэлцүүлж батлуулахаар хүргүүлсэн. /төслийг хавсаргав/	1	50%

26	<i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хэрхэн хамтран ажилласан талаар олон нийтэд тайлагнаж тухай бүр цахим хуудсандаа байршуулдаг.	2	100%
27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Байгууллагын бүтэц, үндсэн үйл ажиллагаа болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудын талаарх мэдээллийг цахим хуудсаараа олон нийтэд нээлттэй мэдээлдэг. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулдаг.	2	100%
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-аас баталсан Эдийн засаг нийгмийн хөгжлийн сангийн журам, Аюулыг илрүүлэх, мэдээлэх, залруулах журам, Сургалтын журам болон бусад журмуудад заасны дагуу жил бүр чиглэл бүрээр төлөвлөгөө гарган ажилладаг. Компанийн цахим хуудсанд улирал бүр өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар байршуулдаг. Өргөдөл гомдол, санал, хүсэлт шийдвэрлэх журмыг мөрдөн ажилладаг. /Журмыг хавсаргав/	2	100%
ДҮН				7	88%
<b>НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ</b> ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Гүйцэтгэх захирлын 2021 оны 04-р сарын 28-ны өдрийн А/95 тоот тушаалаар "Ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн баталсан.	2	100%
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Ёс зүйн дүрмийн 5 дахь хэсэгт "Ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэх" талаар тусгасан байдаг. Цаашид шүгэл үлээгчийн тогтолцоотой болохыг зорин ажиллана.	2	100%
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-өөс ёс зүйн дүрмийг сайжруулан шинэчлэн батлахаар ажиллаж байна. Уг дүрэмд авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар тусгана.	2	100%

ДҮН				6	100%
<b>ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>					
<b>Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана</b>					
32	<i>9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь өөрийн цахим хуудсанд мэдээ мэдээлэл, тайлангуудыг тухай бүр байршуулан ажиллаж байна.	2	100%
33	<i>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i>	Цаашид хэрэгжүүлж ажиллана	Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн төслийг боловсруулан ТУЗ-аар хэлэлцүүлж батлуулахаар хүргүүлсэн. /Хөтөлбөрийн төслийг хавсаргав/	1	50%
34	<i>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь жил бүрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахдаа Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан тогтоолыг мөрдөн ажилладаг. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг ханган ажилладаг.	2	100%
35	<i>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь анхаарч ажилладаг.	2	100%
36	<i>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэмд заасны дагуу их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх үйл ажиллагааг Компанийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулж хэрэгжүүлж байна. 2024 оны байдлаар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй байна.	2	100%
ДҮН				9	90%
<b>НЭГДСЭН ДҮН</b>				<b>66</b>	<b>91%</b>